



## ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/413

Хэрлэн сум

### Зөвлөгөөнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 2023 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хорин гуравдугаар хуралдааны “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 02, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Мал, малын гаралтай түүхий эд, бэлтгэн нийлүүлэлт, анхан шатны боловсруулалт, борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох, загвар хоршоог байгуулах, Хөдөө аж ахуйн Улсын хоршоологчдын зөвлөгөөн-2024” арга хэмжээг зохион байгуулахад 18,000,000 (арван найман сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.


2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, ажлын гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гантөмөр)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
08 дугаар сарын 08-ны өдрийн  
14/13 дугаар захирамжийн хавсралт

"ХӨДӨӨ АЖ АХУЙН ХОРШООЛОГЧДЫН УЛСЫН ЗӨВЛӨГӨӨН-2024" төсөв

№	Хийгдэх ажил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн	Хариуцах эзэн
Зөвлөлгөөний үйл ажиллагаа						
1	Үдийн цай	ш	350	14500	5,075,000.00	АЗДТГазар
2	Сургалтын заалны түрээс	цаг	13	250000	3,250,000.00	
3	Спортын наадам баннер	м2	23.5	18000	423,000.00	
4	Зөвлөлгөөний баннер	м2	24	18000	432,000.00	
5	Мандат	ш	350	3000	1,050,000.00	
6	Гарын авлага	ш	350	22200	7,770,000.00	
Нийт дүн					18,000,000.00	